

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн
2013/27 тоот тогтоолын хавсралт



“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү бодлогын баримт бичгээр “Улаанбаатар БҮК” ХК-ийн /цаашид “компани” гэнэ/ ногдол ашиг хуваарилах, эс хуваарилах нөхцөл, хэлбэр, хугацаа, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг олгох, тайлагнах талаар Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэнэ/-өөс баримтлах бодлогыг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлно.

1.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь энэхүү бодлогын баримт бичгийг компанийн цахим хуудсанд байрлуулж, сонирхсон аливаа этгээдэд тайлбарлах зэргээр хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд танилцуулах үүрэгтэй.

ХОЁР. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ЭС ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ

2.1. Компани нь нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

2.2. Компани энэхүү бодлогын баримт бичгийн 2.4-т заасан нөхцөл байдал үүсээгүй бөгөөд дор дурьдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

2.2.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.2.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.2.3. компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өөрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх.

2.3. Компани дараах нөхцөлд заавал ногдол ашиг хуваарилна. Үүнд:

2.3.1. энэ бодлогын 2.2-т заасан нөхцөл хангагдсан;

2.3.2. компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалт болон бусад тусгай зориулалтын санд зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа.

2.4. Компани эргүүлэн авсан өөрийн халаасны хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТУХАЙ ШИЙДВЭР

3.1. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор буюу жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор ТУЗ гаргана.

3.2. ТУЗ ногдол ашиг хуваарилах тухай шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, тогтоол гарган энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлнэ.

3.3. Ногдол ашгийг мөнгөн болон үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Ямар хэлбэрээр ногдол ашиг төлөх тухай ТУЗ-ийн шийдвэрт заана.

3.4. ТУЗ энэхүү бодлогын баримт бичигт заасан үндэслэлээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэх эрхтэй.

3.5. ТУЗ ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол ногдол ашиг хуваарилаагүй үндэслэл, тийнхүү хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэртээ тусгаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнана.

3.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ногдол ашиг хуваарилсан эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийгэд мэдээлж, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрлэсэн тухай бүр ажлын 3 хоногт Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай" журмын хавсралт МС-4-5 маягтыг бөглөж, мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТАЙЛАГНАХ

4.1. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

4.2. Компанийн холбогдох гүйцэтгэх ажилтнууд ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт заасан ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааны дотор ТУЗ-өөс тогтоосон бүртгэлийн өдөр хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч бүрт тогтоосон хэмжээгээр ногдол ашгийг нь олгоно.

4.3. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрхийг уг хувьцааны хуучин эзэмшигч эдэлнэ.

4.4. Хувьцаа эзэмшигч бүрийн ногдол ашгийг ҮЦТТХТ буюу кастодиан банк дахь дансанд нь шилжүүлнэ. Эсвэл хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дахь дансанд бэлэн бусаар шилжүүлэх бодлого баримтална. Үүний тулд хувьцаа эзэмшигч бүр банкны дансны дугаараа дараах арга хэрэгслээр компанид албан ёсоор мэдэгдэнэ. Үүнд:

- 4.4.1. Компанийн шуудангийн хаяг:
- 4.4.2. Санхүүгийн албаны утас:
- 4.4.3. Цахим хаяг:
- 4.4.4. Уг асуудлыг хариуцсан ажилтны нэр:
- 4.4.5. Албан тушаал:
- 4.4.6. Ажлын утас:
- 4.4.7. Гар утас:
- 4.4.8. Цахим хаяг:

4.5. Данс өөрчлөгдвөл хувьцаа эзэмшигч компанид заавал мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тийнхүү мэдэглээгүйгээс үүсэх хариуцлагыг компани хүлээхгүй.

4.6. Банкны дансны дугаараа мэдэгдээгүй хувьцаа эзэмшигч энэхүү бодлогын баримт бичгийн 4.4-т заасан хаягаар холбоо барьж ногдол ашгаа авна.

4.7. Дансны дугаараа өгөөгүй, энэ баримт бичгийн 4.6-д заасан аргаар ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигч энэ баримт бичгийн 5.2-т заасан нэхэмжлэл гаргах эрхгүй бөгөөд олгогдоогүй ногдол ашгийг энэ баримт бичгийн 4.11-д зааснаар нягтлан бодох бүртгэлд өглөгөөр тусгана.

4.8. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд Гүйцэтгэх захирал нь ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын



15 хоногийн дотор Хороо болон зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээ мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

4.9. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ТУЗ-ийн шийдвэрээр нийгэм, соёлын арга хэмжээни сан байгуулж болно. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэ захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

4.10. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээ хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарил эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайла өглөгийн бүртгэл хөтөлнө.

4.11. Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед Санхүүгийн зохицуула хорооны "Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай" журмын хавсралт МС-4-6 -"Ногдол ашгий хуваарилалтын тайлан"-г гаргаж, хагас жилийн санхүүгийн тайлангийн хамт-Санхүүгийн зохицуула хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнө жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

4.13. Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмы талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүни үндэслэлийг энэхүү ногдол ашгийн бодлогын дагуу тайлбарласан байна.

ТАВ.ХАРИУЦЛАГА

5.1.Ногдол ашгийг хугацаанд нь бүрэн олгоогүй, зар мэдээг журмын дагуу хүргээгүй зэргээр хувьца эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон нь нотлогдвол компанийн буруутай гүйцэтгэ удирдлагын ажилтанд сануулах, цалинг 3 хүртэл сарын хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах ажлаас халах зэрэг сахилгын шийтгэлийг ТУЗ буюу Гүйцэтгэх захирлын шийдвэрээр оногдуулна.

5.2. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол тийнхүү хугацаа хожимдуулсан хоно тутам төлбөл зохих мөнгөний 0,1 хувиар тооцож алданги төлүүлэхээр хувьцаа эзэмшигч шүүхэ, нэхэмжлэл гаргах эрхтэй. Шүүх нэхэмжлэлийг хангах шийдвэр гаргаснаар компанид учирсан хохирлы Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч хамтран хариуцна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Д. Нямхүү



Гишүүд: Хамхоев.Х.Ю

..... Д. Мөнхөө

..... Л. Адилбиш

..... Уромов С.Б.

..... Д. Дэлэг

..... М.Батбаатар

..... Мирзоев Р.Г

..... Ж.Батсайхан

"Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн тухай
журмын хавсралт МС-4-5 маяг



..... АЙМГИЙН /ХОТЫН..... ХК –ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
... ОНЫ /УЛИРАЛ/ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийн огноо, дугаар	Аль оны /улирлын/ ногдол ашиг болох	Нэгж хувьцаанд олгохоор шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ	Ногдол ашгийг олгож эхлэхээр товлосон хугацаа	Ногдол ашгийг олгох хэлбэр / мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас	Ногдол ашгийг хаана олгох /компани дээр, ҮЦТТТХТ, үнэт цаасны компани

Мэдээллийг бэлтгэсэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.....//

Мэдээллийг хянасан ТУЗ-ийн дарга//